**ТӨВ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2023/197/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2023 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай Аудит” ХХК
Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ........ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 14
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 17
4.1 Ерөнхий зүйл........ 17
4.2 Материаллаг байдал........ 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт........ 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал........ 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ........ 19
5.1 Төлбөрийн акт........ 19
5.2 Албан шаардлага ........ 19
5.3 Зөвлөмж ........ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол улсын Ерөнхий аудитор |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/116.

танай ______-ны № ______-т

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
ХҮН ЭМНЭЛГИЙН ДАРГА
М.ТҮВШИНТАМИР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 36,516.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 119,879.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

G/Arkhiv/Alban bichig 2023/ A4
19020200

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhiv/Alban bichig 2023/ A4

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(/төгрөгөөр/)*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **143,774,517.97** | **202,633,861.64** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 8,668,283.57 | 96,574,589.45 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 8,668,283.57 | 96,574,589.45 |
| **3121** | **Төгрөг** | 8,668,283.57 | 96,574,589.45 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 8,631,283.57 | 96,574,589.45 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 37,000.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 75,134,201.21 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 75,134,201.21 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 75,134,201.21 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 59,972,033.19 | 106,059,272.19 |
| **351** | **Түүхий эд материал** | 40,660,091.43 | 71,363,829.83 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,984,143.90 | 7,006,793.90 |
| 35130 | Эм боох материал | 36,675,947.53 | 64,357,035.93 |
| **354** | **Хангамжийн материал** | 19,311,941.76 | 34,695,442.36 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 75,000.00 | 75,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,091,300.00 | 4,091,300.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 650,000.00 | 650,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 773,058.00 | 1,637,588.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,110,463.00 | 2,558,285.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,612,120.76 | 25,683,269.36 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **496,834,346.19** | **596,950,081.74** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 496,834,346.19 | 596,950,081.74 |
| **392** | **Биет хөрөнгө** | 492,784,346.19 | 592,588,231.74 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 333,663,674.00 | 333,663,674.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -38,323,088.12 | -51,161,155.78 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 143,652,325.00 | 150,452,325.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -35,999,040.64 | -52,058,081.26 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 207,524,029.16 | 273,306,290.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -117,863,553.21 | -89,485,440.75 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,206,836.00 | 33,703,712.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,206,836.00 | -5,963,092.40 |
| 39217 | Ном | 130,000.00 | 130,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 4,050,000.00 | 4,361,850.00 |
| 39301 | Программ хангамж | 50,000.00 | 50,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,445,500.00 | 4,311,850.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -445,500.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **640,608,864.16** | **799,583,943.38** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **36,053,912.50** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 36,053,912.50 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 36,053,912.50 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 36,053,912.50 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **604,554,951.66** | **799,583,943.38** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 604,554,951.66 | 799,583,943.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 291,712,432.11 | 291,712,432.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 291,712,432.11 | 291,712,432.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 91,773,992.83 | 286,802,984.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 91,773,992.83 | 91,773,992.83 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 195,028,991.72 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 221,068,526.72 | 221,068,526.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **640,608,864.16** | **799,583,943.38** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **976,750,306.67** | **883,743,626.01** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **733,656,321.67** | **167,114,476.01** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 305,514,621.67 | 167,114,476.01 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 305,514,621.67 | 162,655,002.01 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 4,459,474.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 428,141,700.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 428,141,700.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **243,093,985.00** | **716,629,150.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 75,533,000.00 | 250,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,533,000.00 | 250,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,545,200.00 | 21,773,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,545,200.00 | 21,773,700.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 149,015,785.00 | 694,605,450.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 149,015,785.00 | 694,605,450.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **897,069,741.85** | **688,714,634.29** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **897,069,741.85** | **688,714,634.29** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 896,061,741.85 | 688,425,814.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 323,875,357.19 | 361,654,052.47 |
| 210101 | Үндсэн цалин | 182,308,652.79 | 201,543,172.47 |
| 210102 | Нэмэгдэл | 106,988,557.45 | 135,895,287.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,984,742.95 | 4,353,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,593,404.00 | 19,862,593.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,835,914.75 | 43,020,865.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,175,747.54 | 30,720,206.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,055,632.96 | 3,376,759.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,392,024.80 | 2,590,447.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 564,773.59 | 591,248.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,647,735.86 | 5,742,203.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,992,806.78 | 20,053,590.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,571,083.28 | 5,071,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,421,723.50 | 14,981,790.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,392,228.98 | 39,515,910.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,017,100.00 | 3,205,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,919,000.00 | 31,286,660.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,056,220.00 | 955,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,093,000.00 | 4,068,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,306,908.98 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 370,039,032.19 | 135,034,612.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 356,523,803.69 | 120,521,547.80 |
| 210502 | Хоол, хүнс | 13,515,228.50 | 13,908,065.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 605,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,672,000.00 | 13,818,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 52,000.00 | 126,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,100,000.00 | 95,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 520,000.00 | 13,597,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 840,000.00 | 1,310,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 840,000.00 | 1,310,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 108,414,401.96 | 74,018,783.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,733,760.00 | 17,739,038.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 48,680,641.96 | 56,279,745.66 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,008,000.00 | 288,820.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,008,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,008,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 288,820.00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | 00.00 | 288,820.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **79,680,564.82** | **195,028,991.72** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 14,915,277.60 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 8,754,277.76 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 6,160,999.84 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -14,915,277.60 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **64,765,287.22** | **195,028,991.72** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **595,702,685.00** | **796,215,624.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **428,141,700.00** | **4,459,474.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 4,459,474.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 4,459,474.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 428,141,700.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 428,141,700.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **167,560,985.00** | **791,756,150.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 250,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 250,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,545,200.00 | 21,773,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,545,200.00 | 21,773,700.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 149,015,785.00 | 769,732,450.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 149,015,785.00 | 769,732,450.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **587,034,401.43** | **708,309,318.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **587,034,401.43** | **708,309,318.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **586,026,401.43** | **708,020,498.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 323,882,558.40 | 361,405,051.26 |
| 210101 | Үндсэн цалин | 191,352,367.00 | 201,084,171.26 |
| 210102 | Нэмэгдэл | 97,952,044.45 | 136,105,287.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,984,742.95 | 4,353,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,593,404.00 | 19,862,593.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,835,914.75 | 43,020,865.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,175,747.54 | 30,720,206.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,055,632.96 | 3,376,759.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,392,024.80 | 2,590,447.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 564,773.59 | 591,248.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,647,735.86 | 5,742,203.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,014,288.28 | 19,984,880.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,571,083.28 | 5,071,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,443,205.00 | 14,913,080.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,671,220.00 | 40,269,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,500,000.00 | 3,475,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,115,000.00 | 32,219,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,056,220.00 | 955,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 3,618,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | 25,456,085.00 | 160,472,073.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,539,200.00 | 139,507,884.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,916,885.00 | 15,964,189.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 5,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,400,000.00 | 63,283,950.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.00 | 24,793,300.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 12,100,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,100,000.00 | 3,890,650.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,300,000.00 | 22,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 840,000.00 | 1,310,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 840,000.00 | 1,310,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 143,926,335.00 | 18,274,528.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 143,926,335.00 | 18,274,528.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,008,000.00** | **288,820.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,008,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,008,000.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 288,820.00 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 288,820.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,668,283.57** | **87,906,305.88** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 8,668,283.57 | 87,906,305.88 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 8,668,283.57 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 8,668,283.57 | 96,574,589.45 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөгөөр)*

| Д/д | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 287,712,432.11 | 195,875,816.57 | -114,933,284.68 | 368,654,964.00 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **287,712,432.11** | **195,875,816.57** | **-114,933,284.68** | **368,654,964.00** |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -20,617,002.93 | -20,617,002.93 |
| 8 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **291,712,432.11** | **221,068,526.72** | **91,773,992.83** | **604,554,951.66** |
| 9 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **291,712,432.11** | **221,068,526.72** | **91,773,992.83** | **604,554,951.66** |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 11 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **291,712,432.11** | **221,068,526.72** | **91,773,992.83** | **604,554,951.66** |
| 12 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 13 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 14 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 15 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 16 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 195,028,991.72 | 195,028,991.72 |
| 17 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **291,712,432.11** | **221,068,526.72** | **286,802,984.55** | **799,583,943.38** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 789,749,500.00 | 706,561,024.12 | 83,188,475.88 | 89.47 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 789,749,500.00 | 706,561,024.12 | 83,188,475.88 | 89.47 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 789,749,500.00 | 706,561,024.12 | 83,188,475.88 | 89.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 435,250,600.00 | 359,479,577.26 | 75,771,022.74 | 82.59 |
| 210101 | Үндсэн цалин | 234,037,800.00 | 199,624,697.26 | 34,413,102.74 | 85.30 |
| 210102 | Нэмэгдэл | 140,824,800.00 | 136,105,287.00 | 4,719,513.00 | 96.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,796,000.00 | 3,887,000.00 | 1,909,000.00 | 67.06 |
| 210104 | Урамшуулал | 54,592,000.00 | 19,862,593.00 | 34,729,407.00 | 36.38 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,329,700.00 | 43,486,865.36 | 12,842,834.64 | 77.20 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,440,500.00 | 30,720,206.64 | 8,720,293.36 | 77.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,222,400.00 | 3,376,759.47 | 845,640.53 | 79.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,377,800.00 | 3,056,447.55 | 321,352.45 | 90.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 844,600.00 | 591,248.70 | 253,351.30 | 70.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,444,400.00 | 5,742,203.00 | 2,702,197.00 | 68.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,273,700.00 | 19,984,880.00 | 288,820.00 | 98.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,445,100.00 | 5,071,800.00 | 1,373,300.00 | 78.69 |
| 210302 | Түлш, халаалт | 13,495,600.00 | 14,913,080.00 | (1,417,480.00) | 110.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 333,000.00 | - | 333,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 63,560,000.00 | 40,359,150.00 | 23,200,850.00 | 63.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,210,000.00 | 3,475,350.00 | 2,734,650.00 | 55.96 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,250,000.00 | 32,219,900.00 | 13,030,100.00 | 71.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,500,000.00 | 955,900.00 | 1,544,100.00 | 38.24 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,600,000.00 | 3,708,000.00 | 892,000.00 | 80.61 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000,000.00 | - | 5,000,000.00 | - |
| **2105** | **Норматив зардал** | 121,540,000.00 | 160,382,073.50 | (38,842,073.50) | 131.96 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,720,000.00 | 139,417,884.00 | (40,697,884.00) | 141.23 |
| 210502 | Хоол, хүнс | 17,820,000.00 | 15,964,189.50 | 1,855,810.50 | 89.59 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 63,635,000.00 | 63,283,950.00 | 351,050.00 | 99.45 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 25,500,000.00 | 24,793,300.00 | 706,700.00 | 97.23 |
| 210602 | Тавилга | 12,135,000.00 | 12,100,000.00 | 35,000.00 | 99.71 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,500,000.00 | 3,890,650.00 | 2,609,350.00 | 59.86 |
| 210604 | Урсгал засвар | 19,500,000.00 | 22,500,000.00 | (3,000,000.00) | 115.38 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,500,000.00 | 1,310,000.00 | 1,190,000.00 | 52.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,500,000.00 | 1,310,000.00 | 1,190,000.00 | 52.40 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,000,000.00 | - | 2,000,000.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000,000.00 | - | 2,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,660,500.00 | 18,274,528.00 | 6,385,972.00 | 74.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,660,500.00 | 18,274,528.00 | 6,385,972.00 | 74.10 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 789,749,500.00 | 794,756,150.00 | (5,006,650.00) | 100.63 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 24,552,700.00 | 21,773,700.00 | 2,779,000.00 | 88.68 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 24,552,700.00 | 21,773,700.00 | 2,779,000.00 | 88.68 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 635,300,800.00 | 769,732,450.00 | (134,431,650.00) | 121.16 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 635,300,800.00 | 769,732,450.00 | (134,431,650.00) | 121.16 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 129,896,000.00 | 3,250,000.00 | 126,646,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 129,896,000.00 | 3,250,000.00 | 126,646,000.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 8,631,283.57 | (8,631,283.57) | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 96,574,589.45 | (96,574,589.45) | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 24.00 | 24.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 18.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *[/төгрөгөөр/]*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **37,000.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **37,000.00** |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 37,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **37,000.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 37,000.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **(37,000.00)** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 37,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Эрдэнэ сумын Хүн эмнэлэг нь эрхэм зорилгоо “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэх” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоол “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/А/118 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам ”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэ сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 158,975.1 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 8,668.28 | 96,574.59 | 87,906.31 |
| Авлага | 75,134.20 | - | (75,134.20) |
| Бараа материал | 59,972.03 | 106,059.27 | 46,087.24 |
| Үндсэн хөрөнгө | 496,834.35 | 596,950.08 | 100,115.73 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **640,608.86** | **799,583.94** | **158,975.08** |
| Өглөг | 36,053.91 | - | (36,053.91) |
| Засгийн газрын хувь оролцоо | 291,712.43 | 291,712.43 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 91,773.99 | 286,802.98 | 195,028.99 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 221,068.53 | 221,068.53 | - |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **640,608.86** | **799,583.94** | **158,975.08** |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 87,906.3 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахаар төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж, 96,574.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 75,134.2 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,087.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 42,775.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 100,115.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 36,516.3 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 119,879.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 36,053.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өглөгийг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 635,300.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 24,552.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 129,896.0 мянган төгрөг, нийт 789,749.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 789,749.5 мянган төгрөгийн төсөв батлагснаас орон нутгийн төсвөөс 24,552.7 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 635,300.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 129,896.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 21,773.7 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 769,732.5 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагаанаас 3,250.0 мянган төгрөгийн, нийт 794,756.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 708,309.3 мянган төгрөгийг зарцуулж, 96,574.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 706,561.0 мянган төгрөг буюу 89.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 75,771.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 288.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 23,200.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 351.0 мянган төгрөг, томилолтын зардал 1,190.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 2,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 6,385.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 570,259.30 | - | 570,259.30 | - |
| 1.2 | 80111-Төрийн байгууллагын тогтмол зардал | 24,552.70 | 30,404.98 | (5,852.28) | 123.84 |
| 1.3 | 80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | - | 299,874.35 | (299,874.35) | - |
| 1.4 | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | - | 253,771.73 | (253,771.73) | - |
| 1.5 | 83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | - | 132,889.55 | (132,889.55) | - |
| **Дүн** | | **594,812.0** | **716,940.61** | **(122,128.61)** | **120.53** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 37.0 мянган төгрөгийн тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийг шийдвэрлэх, бараа материалыг зарцуулахдаа ЭАЭЗ аргыг ашиглаж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 727,446.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,911.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаас 75 хувиар буюу 8,183.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 75,771.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 288.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 23,200.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 351.0 мянган төгрөг, томилолтын зардал 1,190.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 2,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 6,385.9 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.
Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 154 мэдээллийг хугацаандаа, 7 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш ажил гүйлгээнээс нийт 65,961.9 мянган төгрөгийн 6 ажил гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, холбогдох албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 86,667.1 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,291.7 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 1,471.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 820.5 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, алдаа зөрчил давтан гарч байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | - | - | - | - |
| Төлбөрийн акт | 1 | 1,471.2 | 1 | 1,471.2 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 820.5 | 3 | 820.5 | 100.0 |
| **Нийт дүн** | **5** | **2,291.7** | **4** | **2,291.7** | **80.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 62,282.9 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 52.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,417.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 60,813.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар 52.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Албан томилолттой холбоотой ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 2 албан хаагчид томилолтын хуудасгүй, бичилт хийгдээгүй баримтаар нийт 52.0 мянган төгрөгийн томилолт олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхийг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй , санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй олгосон томилолтын зардлыг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар 1,417.5 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант онд түлш халаалтын зардлыг 1,417.5 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж, хэмнэлт үүсгээгүй нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байх албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой**

*Илрүүлэлт:*

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 62 нэр төрлийн 59,499.9 мянган төгрөгийн биет хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС-17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх.

**2. Бараа материалын данстай холбоотой**

*Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 22 нэр төрлийн 1,313.5 мянган төгрөгийн эм боох материал /вакцин, эм/ бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Бараа материалыг зарцуулахдаа эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг ашиглаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгттэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан томилолттой холбоотой ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 2 албан хаагчид томилолтын хуудасгүй, бичилт хийгдээгүй баримтаар нийт 52.0 мянган төгрөгийн томилолт олгосон | 1 | 52.0 | 1 | 52.0 | | | | | - | - | - | - |
| Тайлант онд түлш халаалтын зардлыг 1,417.5 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж, хэмнэлт үүсгээгүй | 1 | 1,417.5 | | | 1 | 1,417.5 | | | - | - | - | - |
| Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 62 нэр төрлийн 59,499.9 мянган төгрөгийн биет хөрөнгө бүртгэлтэй | 1 | 59,499.9 | | | | | 1 | 59,499.9 | - | - | - | - |
| Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 22 нэр төрлийн 1,313.5 мянган төгрөгийн эм боох материал /вакцин, эм/ бүртгэлтэй | 1 | 1,313.5 | | | | | 1 | 1,313.5 | - | - | - | - |
| **Дүн** | **4** | **62,282.9** | **1** | **52.0** | **1** | **1,417.5** | **2** | **60,813.4** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 154 мэдээллийг хугацаандаа, 7 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш ажил гүйлгээнээс нийт 65,961.9 мянган төгрөгийн 6 ажил гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй | 1 | 65,961.9 | - | - | 1 | 65,961.9 | | |
| **Дүн** | **1** | **65,961.9** | **-** | **-** | **1** | **65,961.9** | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn